



**МОНГОЛ УДСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: 6226 3168 Факс: (976-11) 312 315,
E-mail: info@mrt.gov.mn, http://www.mrt.gov.mn

2016.05.03 № 08/1863
танай 2016.04.15-ны № 01/1177 -Т

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.НЯМДАВАА ТАНАА

Агаарын зайн хариуцлагын бүсийг
өөрчлөн тогтоох тухай


Танай газраас ирүүлсэн саналын дагуу Улаанбаатар хотын "Чингис хаан" олон улсын нисэх буудлын агаарын зайн хариуцлагын бүсийг өөрчлөн тогтоосон Зам, тээврийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 110 дугаар тушаалыг хүргүүлэв.

Агаарын зайн хариуцлагын бүсэд өөрчлөлт орсонтой холбогдуулан заасан хугацаанд зохих журмын дагуу олон улсад зарлан мэдээлж, аюулгүй байдлыг хангаж ажиллана уу.

Хавсралт: 2 хуудастай.

АГААРЫН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХЭВЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.МӨНХНАСАН





МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Агаарын зайн хариуцлагын бүсийг
өөрчлөн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Иргэний нисэхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дахь заалт болон ИНД-71 'Агаарын зайг тогтоох' дүрмийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Зам, тээврийн сайдын "Нисэх буудлуудын агаарын зайн ангиллыг тогтоох тухай" 2010 оны 412 дугаар тушаалаар баталсан Монгол Улсын нисэх буудлуудын аэродромын удирдлагын бүс, ойртолтын удирдлагын бүс, нислэгийн мэдээллийн үйлчилгээний хариуцлагын бүсийн босоо болон хэвтээ хязгаар, агаарын зайн ангилалд хавсралт ёсоор өөрчлөлт оруулсугай.

2.Энэхүү тушаалаар орсон өөрчлөлтийг 2016 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн олон улсын (UTC) 00:00 цагаас эхлэн нислэгийн үйл ажиллагаанд ашигласугай.

3.Агаарын зайд орж буй өөрчлөлтийн талаар зохих журмын дагуу зарлан мэдээлж, аюулгүй байдлыг ханган ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Г.Нямдаваа/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /С.Мөнхнасан/-т тус тус даалгасугай.

САЙД



М.ЗОРИГТ

